

Иерусалимд ирсэн нь

-Triumphal Entry-



91Page



92Page



93Page



94Page



95Page

Дээгүүр өнгөрөх баяр ойртон ирэв. Эрт үед Бурхан Мосегоор дамжуулан Израильчуудыг Египетийн дарлалаас гарган аварч байсан өдрийг “Дээгүүр өнгөрөх баяр” хэмээн тэмдэглэдэг байв. Энэ баяр болоход тэд Иерусалимын сүмд цуглардаг уламжлалыг дагав. Есүст ч энэ өдөр Иерусалимд очих шалтгаан байлаа.

“Хажуугийн тосгонд очвол илжигний дудран байгаа. Түүнийг хөтлөн авчир. Хэн нэгэн яах гэж байгааг асуувал Эзэнд хэрэгтэй байна гэж хэлээрэй” Дагалдагч нар нь өөрсдийнхөө галуур хувцасыг дундрангийн нуруун дээр тохон түүн дээр Есүсийг суулгав. “Есүс ээ, ядарч байна уу?”, “Зүгээр, зүгээр явцгаая”, Хамгийн дээд Бурханы Хүү Есүс ингэж маш дорд төрхөөр Иерусалим руу явав.

Олон хүмүүс найлзуур модны мөчир барьсаар хашгиригчаав. “Хоззана, Давидын удамын Есүс ээ, биднийг аварч хайрла” хүмүүс Есүсийг хүндэтгэн угтаж өөрсдийнхөө хувцасыг тайлан дудран унан ирж байгаа газар дэвсэж дээгүүр нь явуулав. “Хоззана хамгийн дээд нэгэн, алдарыг авагтун”. Яг л хааныг угтаж байгаа юм шиг Есүсийг угтан авав.

Есүсийн дагалдагч нар ч мөн өөр хоорондоо шивэр авир хийж байв. “Хар даа, Эзэн минь үнэхээр сайхан харагдаж байгаа биз. Удахгүй хаан болох байх даа. Тэр үед би ч бас хааны туслах болно” харин Есүсийн сэтгэл нь огт өөр байлаа. Есүс дэлхийн алдар нэрийг олохын тулд бус Бурханы улсын төлөө хийж байсан юм.

Гэм нүгэлтэй хүмүүсийн төлөө, модон загалмайд цовлогдохын тулд Иерусалим дахь сүмийг чиглэн байлаа.

Иерусалимд ороод Есүс маш их гайхлаа. Тэнд худалдаачид их байв. Тэгээд Есүс худалдаачдад уурлав. “Миний гэр бол бүх үндэстний залбиралын гэр. Та нар юунд Бурханы сүмийг дээрэмчдийн үүр болгоно вэ?”

Есүс бүх худалдаачдыг сүмээс хөөж гаргав. Үүнийг харсан фарисайчууд болон хуулийн багш нар Есүсээс эмээв. Олон хүмүүс Есүсийн үгэнд орж байсан учраас тэр юм. Бурханы үгийг тайлбарлан дамжуулах нь өөрсөдтэй нь адил, боловсорсон хүмүүс л хийж чадах ажил гэж бодож байсан учраас эмээсэн байлаа.